

ГАРЧИГ

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
I.1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
I.2. Төслийн талбайн мэдээлэл.....	2
I.3. Төслийн хэрэгжилтийн явц.....	3
I.4. 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний мэдээлэл	7
БҮЛЭГ II. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	9
БҮЛЭГ III. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
БҮЛЭГ IV. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
БҮЛЭГ V. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ, ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
БҮЛЭГ VI. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
БҮЛЭГ VII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
БҮЛЭГ VIII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	14
БҮЛЭГ IX. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ	14


БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

I.1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Төслийн нэр:	Нарсын хөндлөн нэртэй цагаан тугалганы үндсэн ордыг хосолсон аргаар ашиглах
2	Төслийн баталгаажуулалт:	ЭБМЗ-ийн 2010 оны 07-р сарын 06-ны өдрийн ХХ-09-12 тоот дүгнэлт, АМГ-ын даргын 2010 оны 07-р сарын 29-ны өдрийн 305 тоот тушаалаар В+С зэрэглэлийн хүдрийн нөөц 800,745.4 т, металлын нөөц 5,195.4 т нөөцийг хүлээн авсан.
3	Төсөл хэрэгжүүлэгч компани:	Амирлангуй-Үжин ХХК /9011684019 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй/
4	Компанийн хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, энхтайвны гүүр, Ээрмэлийн гудамж Тайж групп ХХК, 201 тоот
5	Компанийн захирал:	А. Амарбаясгалан
6	Мэйл хаяг:	Ama.bayasaa@gmail.com
7	Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-022391
8	Тусгай зөвшөөрлийн талбай	405 га

I.2. Төслийн талбайн мэдээлэл

Тус талбай нь Дорнод аймгийн Баян-Уул сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос 600 км, аймгийн төв Чойбалсан хотоос баруун хойш 189 км, сумын төвөөс баруун урагш 50 км зайд тус тус оршино (зур.№ 1).



⌘ - Нарсын хөндлөн цагаан тугалганы орд

Зураг №1. Талбайн байршлын тойм зураг

Тус орд нь Нарсын хөндлөн нэртэй MV-022391 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 404.98 га талбайд оршино. Тус талбайн байршлыг зур.№ 2-т, булангийн цэгүүдийн солбицлыг хүсн.№ 1-д тус тус үзүүлэв.



Зураг №2. MV-022391 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн байршил

Хүснэгт № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгийн солбицлууд

Дд	Булангийн цэгийн дугаар	Тэгш өнцгийн солбицол /UTM-48N/		Газар зүйн солбицол /WGS-84/	
		X /м/	Y /м/	B /өргөрөг/	L /уртраг/
1	БЦ-1	5400261.41	613784.27	48° 44' 41.89"	112° 32' 52.04"
2	БЦ-2	5400220.30	611742.27	48° 44' 41.89"	112° 31' 12.04"
3	БЦ-3	5399541.02	611755.82	48° 44' 19.89"	112° 31' 12.04"
4	БЦ-4	5399553.27	612368.50	48° 44' 19.89"	112° 31' 42.04"
5	БЦ-5	5398010.07	612399.45	48° 43' 29.91"	112° 31' 42.04"
6	БЦ-6	5398022.40	613012.49	48° 43' 29.91"	112° 32' 12.05"
7	БЦ-7	5397466.01	613023.71	48° 43' 11.89"	112° 32' 12.05"
8	БЦ-8	5397482.54	613840.71	48° 43' 11.89"	112° 32' 52.04"

1.3. Төслийн хэрэгжилтийн явц

Уг төслийг 2025 оны 5-р сарын 20-оос эхлүүлсэн. Тухайн онд ил уурхайгаас үйлдвэрлэлийн туршилтад шаардлагатай хүдэр олборлолт, баяжуулах үйлдвэр барьж, үйлдвэрлэлийн туршилт явуулах, хаягдлын далан, усан сан байгуулах, ажилчдын кемп байгуулах, зам талбай бэлтгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тухайн онд нийт ажилчдын тоо 79 хүн бөгөөд 17 хүн нь захиргааны хэсэгт, 18 хүн нь ил уурхайд, 40 хүн баяжуулах үйлдвэрт, 4 хүн гэрээт ажилтаны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулсан болно.

Ил уурхайн уулын ажлыг 2025 оны 7-р сарын 20-оос эхлүүлж, 10-р сарын 1-т дууссан. Тухайн оны маркшейдрийн хэмжилт боловсруулалтын үр дүнгээр 33,868 м³ уулын цулыг авсан байна. Үүнээс 19,868 т хүдэр олборлож, үйлдвэрлэлийн туршилтад оруулсан. Ил уурхайн талбайгаас 27,133 м³ массиваар хөрсийг хуулж, хөрсний овоолгын хэмжээ сийрэгжилт тооцсоноор 29,144 м³ -ийг овоолсон байна. Ил уурхайгаас хуулсан 3,417 м³ хоосон чулуулгийг жалга болон

зам талбайн дэвсэлтэд ашигласан байна. Хөрсний овоолгын дундаж урт 160 м, өргөн 73 м, 1170 м түвшинд 1 ярустай, 10.9 мян.м² талбайтай байна.

Шимт хөрсийг уулын бэлд 0.25 м, уулыг орой, энгэр хэсэгт 0.15 м зузаантай хуулж, уурхайн талбайн 2 хэсэгт овоолго үүсгэсэн. Шимт хөрсний овоолго №1-т 5.9 мян.м³ шимт хөрсийг хоосон чулуулгийн овоолгын хажууд, овоолгын дундаж урт 51 м, өргөн 50 м, 1175 м түвшинд 1 ярустай, 2.5 мян.м² талбайд, Шимт хөрсний овоолго №2-д 14.3 мян.м³ шимт хөрсийг түр кемпийн урд талд 30 м зайд, овоолгын дундаж урт 113 м, өргөн 50 м, 1090 м түвшинд 1 ярустай, 4.7 мян.м² талбайд тус тус байгуулсан.

2025 оны 6 сараас баяжуулах үйлдвэрийн угсралтын ажлыг эхлүүлж, 8 сарын сүүлээр ашиглалтад оруулахад бэлэн болсон. 9 сарын 1-ээс үйлдвэрийн туршилт хийж эхлүүлсэн ба 10 сарын 15-д үйлдвэрийн туршилтын ажил дуусгасан байна.

Үйлдвэрийн угсралтын ажил 3 сарын хугацаанд үргэлжилсэн ба хоногт 12 цагаар 1 ээлжээр ажилласан. Угсралтын ажлыг Vехom engineering llc компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж, цагт 10 т хүдэр баяжуулах үйлдвэрийг барьсан. Нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн.

Үйл ажиллагаа явуулахдаа 1000 кВт-ын дизель цахилгаан үүсгүүр ашигласан ба баяжуулах үйлдвэр ажиллахгүй үед бусад хэрэглэгчдийг 100 кВт-ын дизель цахилгаан үүсгүүрээр сэлгэн залгаж хангаж байна. Цахилгаан хэрэглэгчид нь: Баяжуулах үйлдвэрийн хэрэглэгчид: бутлуур, тээрэм, сэгсрэх ширээ, эргэлтийн усны насос; Бусад хэрэглэгчид: түр кемп, засварын газар, нарядын байр. Уурхайн цахилгаан ачааллын тооцоогоор жилд 658.1 кВт цахилгаан зарцуулна.

Үндсэн хэрэглэгч нь уурхайн унд ахуй, баяжуулах үйлдвэр, зам талбайн усалгаа байна. Баяжуулах үйлдвэрээс 180-190 м зайд, урд талд 2 худаг гаргаж, ус хангамжийг шийдвэрлэсэн байна. Тус худгуудыг ашиглалтад бэлэн болгож, ЭЦВ 10-150-70 маркийн 33 кВт чадалтай насосоор тоногдсон ба худгийн үзүүлэлт нь 54 м гүнтэй, ундарга 155 м³/хон байна.

Хоёр худагны дунд хэсэгт цэвэр ус хуримтлуулах сан байгуулсан. Тус сангаас цэвэр ус сан руу үйлдвэрийн нэмэлт усыг хангах ба тус цэвэр усан сангаас үйлдвэрийг усаар тэжээнэ. Үйлдвэрээс гарсан шлагмыг хаягдлын цөөрөмд хуримтлуулж, тунгаагаад эргүүлэн усан санд өгнө. Үйлдвэр эргэлтийн усны системээр явагдана.

Олон салаа зам үүсгэж, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах зорилгоор уурхайн талбайн объектуудыг холбосон замын сүлжээ байгуулсан. Ил уурхай баяжуулах үйлдвэрийг холбосон технологийн замыг 11 м өргөнтэй 2 урсгалтай, 1 км урттай сайжруулсан зам тавьсан. Ил уурхайгаас олборлосон хүдрийг овоолох зориулалттай 15,000 м² талбай бэлтгэсэн. Ил уурхайгаас гаргасан хоосон чулуулгийн зам талбайд дэвсэж, дугуйт ачигчаар тарааж, тэгшилж, индүүгээр дагтаршуулж, нягтруулалтыг удаа дараа давхарласан болно.

Кемпийн 8,700 м² талбайд 4 ш гэр, 8 ш зөөврийн сууц, 1 ш сэлбэг материал агуулах, 1 ш хүнсний агуулах, урд талд бетонон сууртай хогийн цэг, зүүн талд хүндийн зогсоол болон ариун цэврийн байгууламж байгуулсан. 1 ш зөөврийн сууцыг оффис, 1 ш зөөврийн сууцыг гал тогоо, 1 ш зөөврийн сууцыг хүнсний агуулах, 1 ш зөөврийн сууцыг ахуйн үйлчилгээний газар болгож тохижуулсан байна.

Өөрийн жингээр урсгахаар зохион байгуулж, булинга хуримтлуулах хаягдлын цөөрөм 1 ш байгуулсан. Хаягдлын цөөрмийн байгууламж нь далан, хаалт, хаягдлын сан, булинга дамжуулах хоолой, насосын станц зэргээс бүрдэнэ. Хаягдлын цөөрөм нь 16,200 м² талбайтай, 67.0 мян.м³ багтаамжтай байна.

Баяжуулах үйлдвэрээс 37 м зайд, тэгш талбайд ухалт болон далан байгуулалт хийж, цэвэр усан санг байгуулсан. Усан сангийн талбайн хэмжээ 3,772 м², 7 хоногийн нөөц бүхий 5.2 мян.м³ усыг хадгалах багтаамжтай байна.



Зураг №3. Кемпийн харагдах байдал



Зураг №4. Уурхайн талбайн харагдах байдал



Зураг №5. Баяжуулах үйлдвэрийн харагдах байдал



Зураг №6. Хаягдлын цөөрмийн харагдах байдал



Зураг №7. Усан сангийн харагдах байдал

I.4. 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний мэдээлэл

Жилийн хүчин чадал. Энэ онд ТЭЗҮ-д тусгасны дагуу ил уурхайгаар олборлох үлдэгдэл хүдэр болох 62.69 мян.т хүдрийг олборлож, баяжуулахаар төлөвлөв.

Ашиглах хугацаа. Тус ордыг хосолсон аргаар 5 жилийн хугацаанд олборлох ба баяжуулах үйлдвэр 10 жилийн хугацаанд ажиллана. 2025 онд үйл ажиллагаа явуулснаар ашиглалтын хугацаа 9 жил болсон.

Ажиллах горим. Уулын ажлыг дулааны улиралд 4 сарын 1-ээс 10 сарын 30 хүртэл 205 хоногийн хугацаанд 12 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр явуулна. Баяжуулалт 200 хоногт 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар төлөвлөсөн.

Ашиглалтын систем: Экскаватор-автосамосвал хослол бүхий гадаад овоолготой ашиглалтын системээр уулын ажлыг явуулна.

Уулын ажлын процесс: Уулын дээд хэсгийн өгөршилттэй хэсгийг экскаватороор шууд утгаж, хөрс хуулалт болон хүдэр олборлолт хийнэ. Шууд утгах боломжгүй болох үед молдок ашиглаж, төлөвлөсөн гүн хүртэл ашиглалт явуулна. Ил аргаар ашиглахад өрөмдлөг-тэсэлгээгүйгээр явуулахаар төлөвлөсөн. Хөрс болон хүдрийг зориулалтын овоолго үүсгэж, тээвэрлэнэ.

Ашиглалтын системийн элементүүд: Ордын талбайг бүрхсэн дөрөвдөгчийн 1.45 м зузаантай хөрсийг экскаватороор шууд утгана. Үүнээс 0.30 м зузаантай үржил шимт хөрсийг тусад нь хуулна. Хөрсний доголын өндрийг экскаваторын утгалтын гүнээс хамааруулан 5 м-ээр явуулах ба ашиглалтын эцэст 15-20 м өндөртэй нэг догол болгон хаалт хийнэ. Ашиглалтын эцсийн байдалд доголын налуу 60°. Ашиглалтын үеийн хөрс ба хүдрийн доголын налуу, ажлын талбайн өргөн зэрэг ашиглалтын системийн элементүүдийг тус ордын чулуулгийн физик-механикийн шинж чанарын үзүүлэлтүүд, экскаваторын утгалтын үеийн техник, аюулгүйн дүрмийн шаардлагын дагуу дараах хэмжээсүүдээр авч төсөлд тусгав. Үүнд:

Ажлын доголын өндөр – 5 м;

Ажлын доголын нүүрний налуу - 50°;

Ажлын доголын хажуугийн налуу - 60°;

Доголын нурлын аюулгүйн зай – 3 м;

Ажлын талбайн хамгийн бага өргөн – 12 м;

Ажлын бус доголын налуу үндсэн чулуулагт - 60°;

Өгөршсөн болон дөрөвдөгчийн хөрсөнд - 41°.

Экскаваторын ачилт нь ордын өргөнөөр явах боловч зарим тохиолдолд түүнээс ч бага хэмжээнд явагдахаар байна.

Ашиглах техник. Ухаж ачихад 1.8 м³ шанагатай өөрийн техник болох CAT 336D маркийн экскаватор 1 ш, 2.4 м³ шанагатай өөрийн техник болох CAT 336D маркийн молдоктой экскаватор 1 ш, тээвэрлэлтэд 25 т даацтай өөрийн автосамосвал 2 ш, зам талбайн ажилд 3 м³ хусуурын багтаамжтай өөрийн дугуйт ачигч 1 ш тус тус ашиглана.

Хүснэгт №.2. CAT 336D маркийн экскаваторын техникийн тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	Утгуурын багтаамж	м ³	1.8
2	Хөдөлгүүрийн төрөл	-	Cat C9 ACERT
3	Хөдөлгүүрийн чадал	кВт	198.4
4	Гинжний хэмжээ: урт х өргөн	м	5.02×3.3
5	Явах хурд	км/цаг	5.0
6	Экскаваторын овор хэмжээ: урт×өргөн×өндөр	м	10.9×3.5×3.6
7	Жин	т	30.5
8	Түлшний савны багтаамж	л	620
9	Ачилтын хамгийн их өндөр	м	6.6
10	Утгалтын хамгийн их гүн	м	6.5
12	Утгалтын хамгийн их радиус	м	10.2
13	Ачилтын хамгийн бага радиус	м	2.9

Хүснэгт №3. Автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1	Даац	т	25
2	Жин	т	24
3	Тэвшний багтаамж	м³	16
4	Дээд хурд	км/цаг	85
5	Хөдөлгүүрийн чадал	кВт	246
6	Эргэлтийн радиус	м	9
7	Тэвшний өргөн	м	2.3
8.1	Овор хэмжээ: - урт	м	8.2
8.2	- өргөн	м	2.5
8.3	- өндөр	м	3.3




Хүснэгт №4. Дугуйт ачигчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	
1	Өөрийн жин	т	17.5	
2	Хөдөлгүүрийн чадал	кВт	162	
3	Утгуурын багтаамж	м³	3.0	
5	Овор хэмжээ	м	8.22×3.02×3.51	
6	Материалыг асгах өндөр	м	3.1	
7	Эргэлтийн радиус	м	6.5	
8	Туулах налуу	град.	38	
9	Хурд	I араа	км/цаг	13/17
		II араа	км/цаг	41


Хүснэгт №5. хацарт бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Хүлээн авах амсрын хэмжээ, мм	650×750
2	Тэжээл дэх хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм	500
3	Асгах амсрын хэмжээ, мм	25 – 60
4	Бүтээмж, т/цаг	100
5	Хөдөлгүүрийн хүчин чадал, кВт	55




Хүснэгт №6. Конусан бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Хүлээн авах амсрын диаметр, мм	100
2	Тэжээл дэх хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм	50
3	Асгах амсрын хэмжээ, мм	18
4	Бүтээмж, т/цаг	100
5	Хөдөлгүүрийн хүчин чадал, кВт	50
6	Жин, кг	530




Хүснэгт №7. Тээрмийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Марк	Ø900×1800
2	Жин, т	5.5
3	Эргэлтийн хурд, эрг/мин	36-38
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	18.5
5	Гаргах ширхэглэлийн хэмжээ	0.89-0.074
6	Бүтээмж, т/цаг	5



Хүснэгт №8. баяжуулах ширээний техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Урт, мм	4500
2	Дамжуулах өргөн, мм	1300
3	Баяжмал дамжуулах өргөн мм	1000
4	Тэжээлийн хамгийн том хэмжээ мм	2
6	Тавцангийн өөрчлөгдөх налуу	2°30 – 4°30
7	Тавцангийн налуу	1.4
9	Хөдөлгүүрийн чадал, кВт	1.1



БҮЛЭГ II. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Уурхайн хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагааны улмаас уурхайн орчны тоосжилт нэмэгдэх магадлалтай. Янз бүрийн зориулалт бүхий уулын ажил, хаягдал чулуулгийн овоолго, инженерийн болон аж үйлдвэрийн барилга байгууламж барьж байгуулахад газрын гадарга эвдэрч хиймэл рельеф үүсэх. Газар тариалан, бэлчээрийн зориулалттай талбайн хэмжээ багасаж үр өгөөж нь буурах зэрэг болзошгүй сөрөг нөлөөлөл бий болох эрсдэлтэй байна.

Машин механизмын үүсгэж буй хөрсний тоос, ачих буулгах ажлын тоос болон дотоод шаталтат хөдөлгүүрийн утаа агаарт ялгаруулах явцыг бууруулах зорилгоор дээрх хорт бодисуудыг бага ялгаруулдаг техник, технологи ашиглах арга хэмжээ авна. Түүнчлэн уурхайн эргэн тойрон ногоон бүс байгуулж салхинд хийсэх сул шороог багасгана. Тоос шороог дарахын тулд байнгын усалгаа хийнэ.

Үйл ажиллагааны явцад хөрсний дээж авч лабораторийн дүгнэлтэд үндэслэн олборлолт, үйлдвэрлэлийн явцад үүсэх хөрсний эвдрэлийг бага байлгах арга хэмжээ авна.

Уурхайн ажлын явцад хөрс хуулалтын ажлыг технологийн дагуу явуулж, хуулсан шимт хөрсийг аль болох хурдан нөхөн сэргээлтэд ашиглана. Өнгөн хөрсийг нөхөн сэргээлтэд шууд ашиглахгүй хадгалах нөхцөлд идэгдлээс хамгаалж доторх бичил организмын амьдралыг тэтгэх үүднээс гадаргууг нь ургамалжуулах арга хэмжээ авна.

Төсөл хэрэгжих явцад нутгийн ургамал, амьтанд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авна.

Олборлолт болон үйлдвэрлэл явуулах талбайн ургамлын нэр төрөл тархалтыг тогтоож ховор болон нэн ховор ургамал байвал хамгаалах, шилжүүлэх арга хэмжээ авна.

Тухайн орчинд амьдарч байгаа ан амьтны байршил, тоо толгойг тогтоон олборлолтын ажиллагаанаас учрах сөрөг нөлөөллийг тогтоож багасгах, арилгах арга хэмжээ авахаас гадна төслийн явцад ургамал ан амьтанд нөлөөлөх нөлөөллийн хяналтыг явуулна.

Төслийн үйл ажиллагаанаас гарах үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй байх талаас анхааран арга хэмжээ авч хогийг зайлуулна.

БОНУ-д тусгасны дагуу сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөг гаргаж доорх хүснэгт №6-д үзүүлэв. Тухайн ажилтай холбоотой зардлыг БОНУ-д тусгасны дагуу 9.7 сая төгрөгөөр төлөвлөж, энэхүү БОМТ-д тусгаж байна. Төлөвлөгөөнд тусгасан зардлаас илүү гарсан тохиолдолд үйл ажиллагааны зардлаас гарган гэж үзэж байна.

Хүснэгт №9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Уурхайн дотоод тээвэр, баяжуулалтын хэсэгт тогтмол тоосжилт дарах усалгааны ажлыг гүйцэтгэж их хэмжээгээр тоосжилт үүсэн орчинд тархахаас сэргийлж ажиллах	Уурхайн бүсэд	-	Хуваарийн дагуу	Ус ашиглалтын төлбөрийн дүнгээр	Үйл ажиллагааны турш	-Агаарын тухай хууль MNS 4585:2016 -Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5014:2019 - Дизель хөдөлгүүртэй машин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Усны тухай хууль -Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам MNS BS 8525-1:2015 Саарал усны систем. Ерөнхий шаардлага MNS 4288:1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4047:1988 БОХ. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам MNS ISO 5667-6:2001 БО. Усны чанар. Дээжлэлт. 6р хэсэг: Гол, горхины уснаас дээж авах заавар MNS 0900:2018 ХБО. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл
2		Уурхайн техник, хэрэгслийн үзлэг, засвар, агаарын бохирдлын төлбөр	Уурхайн техник хэрэгсэл			Үйл ажиллагааны зардлаар	Тухай бүрт	
3		Дотоод хяналтын багажаар тогтмол хугацаанд хэмжилт хийснээр тохиромжтой хугацаанд сөрөг нөлөөллийг бууруулан стандартад байлгах	Уурхайн бүсэд	ш	2	2.0	III болон IV-р улиралд багтаан	
4		Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотойгоор тоосжилт дарах	Уурхайн бүсэд			тогтмол	Ус ашиглалтын төлбөрийн дүнгээр	
1	Усны чанар	Гүний худгийн тоолууржуулах, ажиллагааг тогтмол хянах	Уурхайн кемпийн талбай			тогтмол	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны турш
2		Худгийн байрны дотор талыг тогтмол цэвэрлэж ариутгал халдваргүйжүүлэлт хийж мөөгөнцөр үүсэхээс сэргийлэх	Худаг	ш	2	2.0	III болон IV-р улиралд багтаан	
3		Ус ашиглалтын гэрээ байгуулж төлбөрийг тогтмол төлөх	Уурхайн бүсэд	ш	1		Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны турш
1	Хөрсөн бүрхэвч	Олборлолт нэмэгдэх бүрд шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Уурхайн бүсэд			Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагаа явуулж буй хугацаанд
2		Асгарсан тос масло хөрс бохирдуулагч аливаа бодис асгарсан тохиолдолд гүнд	Уурхайн бүсэд			Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагаа явуулж буй хугацаанд

		нэвчихээс сэргийлэх арга хэмжээ авах						ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль ЗГ-ын 2021.11.17 ны өдрийн 350 р тогтоолоор батлагдсан - Ургамал хамгааллын тухай хууль -Амьтны тухай хууль -Байгаль орчныг хамгаалах тухай хууль
3		Авто зам болон явган хүний замыг тэмдэгжүүлэх, олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн бүсэд		Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагаа явуулж буй хугацаанд	
1	Амьтны аймаг	Уурхайн карьерт ухсан далан нүхэнд мал, амьтан унаж эрсдэхээс хамгаалж торон хашаа хамгаалалт хийх	Уурхайн бүсэд	удаа	1	Үйл ажиллагааны зардлаар	Ш-р улиралд багтаан	
2		Төслийн талбайн ойролцоох ан амьтад хэт их чимээ, хүний хөдөлгөөнөөр дайжих	Уурхайн бүсэд		Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагаа явуулж буй хугацаанд	

БҮЛЭГ III. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

БОНУ-д 2026 онд дүйцүүлэн хамгаалахаар санал болгосон газар нутагт зэрлэг ан амьтдын судалгаа хийлгэхээр 7.47 сая төгрөг тусгасан байна. Энэхүү мөнгөн дүнгээр дүйцүүлэн хамгаалах ажлыг хийхээр төлөвлөж, БОМТ-д тусгаж байна.

Орон нутгийн байгаль орчны мэргэжилтэн уурхайн талбайд ирж, биологийн янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутагтай уулзаж, хаана ямар талбайд ямар ажил хийхийг тохиролцон гүйцэтгэх талаар зөвлөсний дагуу ажлыг гүйцэтгэхээр тусгаж байна.

БОМТ батлагдсны дараа орон нутгийн байгаль орчны газартай дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд уулзалт хийнэ. Дүйцүүлэн хамгаалах ажлыг III-р улиралд багтаан хийхээр төлөвлөв.

БҮЛЭГ IV. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоомж, зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй. БОНУ-д тусгаснаар 2026 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй гэж тусгасан ба төсөл дөнгөж хэрэгжиж эхэлж буй тул ямар нэг нөхөн сэргээлтийн ажил 2026 онд хийгдэхгүй болно.

БҮЛЭГ V. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ, ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно

Төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Иймд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажлыг төлөвлөгөөгүй болно.

БҮЛЭГ VI. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдлийн менежментийг БОНУ-д тусгасны дагуу ажлуудыг хийхээр төлөвлөж, доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №10. Осол эрсдлийн менежмент төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хугацаа ба давтамж
Уурхай хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Жил бүр
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилттай өдөрүүдэд тамхины цог зэргээс түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм боловсруулан мөрдлөг болгож ажиллах	Дотоод журам	2026
	Ажилчдыг гал түймэр унтраах сургалтанд хамруулах	Дотоод зардлаар	Жилд 1 удаа
	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	500.0	Жил бүр
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах		Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	500.0	Жилд 1 удаа
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар	Жил бүр
Нийт		1000.0	

БҮЛЭГ VII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах хогийн цэг байгуулах ба аюултай хог хаягдлын цэгийн доод талын суурийг бетондож, хөрсөнд шингэхээс сэргийлнэ. Үйл ажиллагаа эхлэх үед орон нутгаас хог хаягдлыг кодлуулж, хог хаягдлын гэрээ хийх ажлыг нэн яаралтай хийнэ. Хог хаягдал зайлуулах тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ хийсний дагуу уурхайн хог хаягдлыг ачих, устгах ажлуудыг гүйцэтгэнэ.

Хүснэгт №11. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө

Төслийн сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлын цэг, кемп орчим бохирдох	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг зохион байгуулах	960.0	Хог хаягдлын тухай хууль, журам стандарт
Аюултай	Аюултай хог хаягдлыг кодлон ялгаж бүртгэлжүүлэх, стандартын дагуу байгуулсан агуулахад хадгалах, нийлүүлэгч талд буцаан өгөх, сав баглаа боодлын хор аюулыг саармагжуулах эсвэл нийлүүлэгч талд буцаан өгөх арга хэмжээнүүдийг тодорхойлох	400.0	
	Аюултай хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	
Ахуйн бохир ус	Ахуйн шингэн бохирыг цэвэрлэх эко төхөөрөмж тавих	Үйл ажиллагааны зардлаар	
Нийт		1360.0	

БҮЛЭГ VIII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм

Хүснэгт №12. Орчны хяналт-шинжилгээний төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал мян.төг	Баримтлах арга, аргачлал, стандарт шаардлагууд
Агаарын чанар				
Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх	Ил уурхай орчим Хөрсний овоолго Баяжуулах үйлдвэр орчим Гадаад тээврийн зам Кемпийн талбайн урд	III болон IV улиралд	480.0	MNS 4585:2016 MNS 3384:1982 MNS 4048:1988 MNS 5014:2009 MNS 0017-2-5-11:1988
Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх				
Дуу чимээ				Ил уурхайн орчимд Баяжуулах үйлдвэр орчим Кемпийн талбай Гадаад тээврийн зам
Усны хяналт шинжилгээ				
Микробиологийн шинжилгээ	Гүний худаг Ундны ус	III улиралд	560.0	MNS 0900:2018
Бохирдуулагч бодис	Бохирын цооног	III улиралд	170.0	MNS 4943:2015
Хөрсний хяналт шинжилгээ				
Хөрсний агрохими	Хатуу хог хаягдлын цэг Кемпийн талбай Баяжуулах үйлдвэр орчим Шимт хөрсний овоолго Уурхайн ам Дотоод зам дагуу, ШТС Эрүүл талбай	IV улиралд	120.0	MNS 3928:1991 MNS 5850:2019 MNS 3985:1987 MNS 3310:1991 MNS 2305:1994
Хөрсний хүнд элементүүд				
Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ				
Ургамлын хяналт шинжилгээ				
Ургамал устгах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, био масс багасах	Төсөл хэрэгжих байршил болон түүний ойр орчим 4 цэгт	IV улиралд	500.0	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтран ажиллах
Нийт			1830.0	

БҮЛЭГ IX. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

БОМТ-д тусгасан ажлуудыг хийхэд шаардагдах зардлыг төрөл тус бүрээр тооцоолж, нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв. 2026 оны байгаль орчны ажлаар 21.37 сая төг зарцуулах ба байгаль орчны санд 10.69 сая төг хуримтлуулахаар байна.

Хүснэгт №13. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний 2026 оны зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээний төлөвлөгөө	9700.0
2	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	7476.46
3	Осол эрсэлийн менежментийн төлөвлөгөө	1000.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1360.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1830.0
6	Нийт	21366.46